



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/101

Хужирт сум

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 33 дугаар зүйлийн 33.1.5.1, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Дулаан 6 дугаар багийн “Дулааны зүүн суу” гэх газарт малчин Чулуунбатын Нэргүйн бог малаас малын гоц халдварт мялзан өвчин илэрсэн нь Улсын Мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 23-4057 дугаартай шинжилгээгээр батлагдсан тул сумын Мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн 5 км радиуст голомтын бүс тогтоож 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосугай.
2. Хорио цээрийн дэглэмийн үед ажиллах Мэргэжлийн багийг хавсралтаар байгуулсугай.
3. Дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт байгаа малтай өрхүүдийн малд тандалт шинжилгээ хийж, дархлаажуулалтын ажил болон ариутгал халдваргүйжүүлэлтийг яаралтай зохион байгуулж ажиллахыг Мэргэжлийн баг (Б.Ичинхоролцэвэлмаа)-т үүрэг болгосугай.
4. Хорио цээрийн дэглэмийн үеэр хяналтын 1 пост, хөдөлгөөнт 2 эргүүл гаргаж техник хэрэгсэл, хүн хүч дайчлан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга З.Цэцэгмаа, шаардагдах шатах тослох материал, халдваргүйжүүлэлтийн хувцас хэрэгсэл, ариутгалын бодисоор хангаж ажиллахыг Нягтлан бодогч Г.Оюунмандах нарт тус тус даалгасугай.
5. Малчдад мялзан өвчний талаар сэрэмжлүүлэг, мэдээлэл хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.